

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ

А.Амгаланбаяр

*Дотоод Хэргийн Их сургуулийн
Удирдлагын академийн Хилийн
албаны удирдлага, стратегийн
тэнхимийн дэд профессор, дэд
хурандаа*

Товч агуулга: Хилийн аюулгүй байдал нь улс орны үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ хилийн аюулгүй байдалд зөвхөн цэргийн хүч ашиглах бус, эдийн засгийн аргаар хангах боломжтой. Энэ илтгэл нь хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хэрхэн сайжруулах боломжийг судлахад чиглэгдсэн. Гааль, татварын бодлого, хилийн хамгаалалтын санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа, эдийн засгийн хориг арга хэмжээ зэрэг эдийн засгийн аргууд нь хилийн аюулгүй байдалд хэрхэн эерэг нөлөө үзүүлж болохыг илрүүлэх зорилго тавьсан.

Түлхүүр үгс. Хилийн аюулгүй байдал, эдийн засгийн арга, гааль, татвар, санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа, хилийн хамгаалалт, эдийн засгийн хориг.

Удиртгал

Хилийн аюулгүй байдал нь улс орнуудын үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн

хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Уламжлалт хилийн аюулгүй байдлын арга барил нь голдуу цэргийн хүч, хууль сахиулах арга хэмжээ дээр суурилдаг ч, эдийн засгийн аргууд нь энэ асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй. Эдийн засгийн аргуудыг ашиглан хилийн аюулгүй байдлыг сайжруулах нь зөвхөн хилээр орж ирж буй бараа, бүтээгдэхүүний хяналт болон хууль бус үйл ажиллагааг зогсоох төдийгүй, хил, хил орчмын бүс нутагт аюулгүй байдлыг бүрдүүлэхэд ч чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэхүү илтгэл нь хилийн аюулгүй байдалд эдийн засаг хэрхэн нөлөөлөхийг судалж, эдийн засгийн бодлогын үр дүнтэй хэрэглээний талаар авч үзэх болно.

Хилийн аюулгүй байдал

Хилийн аюулгүй байдал нь төр, нийгэм, иргэдийн амин чухал эрх ашгийг хамгаалах зорилгоор улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэр дээр хуулийн дагуу хяналт тавих, аюулгүй байдлыг хангах үйл явц бөгөөд хилээр орох, гарах хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох, терроризм, гэмт хэргийн асуудлыг шийдвэрлэх явдал юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь “Монгол Улсын Үндсэн хууль”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах

бодлого”, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын хилийн тухай хууль”, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр (Жанцан, Ц., 2012), манай улсын нэгдэн орсон конвенцууд юм.

Дэлхий дахинд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулах онцгой эрх бүхий субъект нь тусгаар тогтносон улс байдаг.

Тусгаар тогтносон улс нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дараах шинжийг зайлшгүй хангаж байх шаардлагыг хангасан байх ёстой.

Үүнд:

- Нутаг дэвсгэртэй байх;
- Засаглалтай байх;
- Харьат иргэдтэй байх тус

тус болно.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь:

1. Монгол Улсын Засгийн Газраас явуулж байгаа олон улсын төр, дипломат гадаад харилцааны ажиллагаа

2. Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хилийн зурвас, бүсэд хууль сахиулах ажиллагаа,

3. Хилийн орон зайд бий болж болзошгүй цагийн байдлын өрнөлтийн ямар нөхцөлд шилжин ажиллах бэлэн байдлыг ханган явуулж буй алба-байлдааны ажиллагаа

4. Батлан хамгаалах нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүнд цэргийн ажиллагаа байдаг.

Хилийн халдашгүй дархан байдал нь олон улсын гэрээ эрх зүйгээр зохицуулагддаг бол хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь улсын дотоод хууль эрх зүйгээр зохицуулагддаг, харилцан нарийн уялдаатай системүүд юм.

“Монгол Улсын Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана” (хууль, 2016) гэж тусгажээ.

Эдийн засгийн аргын үүрэг

Эдийн засгийн аргууд нь хилийн аюулгүй байдлыг хангах чухал хэрэгсэл юм. Эдгээр аргууд нь улс орнуудын гааль, татвар, санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагаанд тусгалаа олдог.

Гааль, татварын бодлого

Гааль болон татварын бодлого нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл явцад чухал үүрэгтэй. Хилийн боомтуудад хяналт тавих, хууль бус бараа, бүтээгдэхүүн, мансууруулах бодис болон эмийн хортой бодис,

терроризм зэрэг аюултай зүйлсийг зогсоох үүднээс гаалийн хяналт шаардлагатай. Гааль нь хил дамжин орж ирэх бараа бүтээгдэхүүнийг хянах, тээвэрлэх болон худалдаалах аюулгүй байдлыг хангах зорилгоор үндсэн эдийн засгийн арга хэрэгсэл болдог.

Хилийн хамгаалалтын санхүүжилт

Хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар бэхжүүлэхийн тулд хилийн хамгаалалт, хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэх нь чухал юм. Үүний тулд улс орны төсвөөс хөрөнгө оруулалт хийх, хилийн хамгаалалттай холбоотой бүхий л байгууламжийг шинэчлэх, хилийн хамгаалалтын дэвшилтэт технологийг ашиглах шаардлагатай.

Эдийн засгийн хориг арга хэмжээнүүд

Хилийн аюулгүй байдлын хямралтай холбоотойгоор эдийн засгийн хориг арга хэмжээнүүдийг ашиглах нь үр дүнтэй байж болно. Олон улсын эдийн засгийн хориг нь хил орчмын бүсэд эдийн засгийн аюулгүй байдлыг хадгалах зорилгоор зарим улс оронд хориг тавихад хэрэглэгддэг. Жишээ нь, эдийн засгийн хориг нь терроризм, мансууруулах бодисын худалдаа зэргийг зогсоох чиглэлээр үйл ажиллагааг дэмжиж чадна.

Олон улсын хамтын ажиллагаа

Олон улсын хамтын ажиллагаа нь хилийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Улс ордуудын хоорондох худалдааны гэрээ, эдийн засгийн тусламж, хилийн аюулгүй байдлын талаарх хамтын ажиллагаа нь аливаа аюултай үйлдлээс сэргийлэх, хууль бус бараа, бүтээгдэхүүнийг хилээр дамжуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг.

Эдийн засаг гэж юу вэ?

Эдийн засаг нь хүн төрөлхтний хязгааргүй хэрэгцээг хангахын тулд хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай хуваарилж ашиглах асуудлыг судалдаг шинжлэх ухаан юм (Цэдэндагва, Г, 2013). Хязгаарлагдмал нөөц нь нийгэм, улс орон бүрд байдаг бөгөөд эдгээр нөөцийн хэрэглээний үр ашиг нь аль болох өндөр байх ёстой. Хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хангах нь эдгээр хязгаарлагдмал нөөцийг зөв, үр ашигтай ашиглахын тулд шаардлагатай аргуудыг зохицуулах, хөрөнгө оруулалт, техникийн дэвшилтэт шийдлүүдийг ашиглах зэрэг олон хүчин зүйлийг нэгтгэдэг.

Эдийн засгийн хүчин зүйлст:

- Гадаад эдийн засгийн орчин - (улс орны эдийн засгийн үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомж, валютын ханш болон гадаад худалдаа зэрэг олон хүчин зүйлсийн олон улсын түвшинд үүсэх нөхцөл байдал)

- Гадаад инфляц - (гадаад орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн, нэг улсын эдийн засагт инфляцын дарамт үүсэх үйл явц)

- Түүхий эдийн үнэ ханш - (бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг дэлхийн зах зээл дээр худалдаж авах болон борлуулах үнэ)

- Дотоод эдийн засгийн орчин - (улс оронд хэрэгжиж буй эдийн засгийн нөхцөл байдал, бодлого, хууль тогтоомж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний үйлчилгээ үзүүлэгчид зах зээлд тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, түүнд зарцуулах чадварын хэмжээг илэрхийлнэ)

- Мөнгө, зээлийн үзүүлэлт - (**Мөнгө** нь эдийн засгийн үйл ажиллагаанд хэрэглэхэд тохиромжтой, солилцооны хэрэгсэл, үнэ цэнийг хэмжих нэгж, хөрөнгө хадгалагчийн үүрэг гүйцэтгэдэг. **Зээлийн үзүүлэлт** нь санхүүгийн салбарт зээл олгох нөхцөл байдал, зээлийн хэмжээ, түүний хүү, эрсдэл, хариуцлагатай зээл олголт зэрэг олон хүчин зүйлсийг хэмждэг үзүүлэлт юм)

- Төлбөрийн тэнцэл - (Төлбөрийн тэнцэл (*Balance of Payments*) нь тухайн улсын гадаад эдийн засгийн бүх гүйлгээг нэгтгэн харуулдаг санхүүгийн баримт бичиг юм. Энэ нь тухайн улсын гадаад худалдаа, гадаад хөрөнгө оруулалт, зээл, гадаадын валютын урсгал зэрэг эдийн

хэв маяг болон эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих орчин)

- Эрэлт, хэрэгцээ, нийлүүлэлт - (**Эрэлт** нь хэрэглэгчид тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах хүсэлтэй байгаа хэмжээ, түүнчлэн түүнийг худалдан авах чадварын хэмжээг илэрхийлнэ. **Хэрэгцээ** гэдэг нь хүмүүсийн амьдралд хэрэгцээтэй, шаардлагатай гэж үзсэн зүйлс. **Нийлүүлэлт** нь үйлдвэрлэгчид эсвэл

засгийн үйл ажиллагааг бүрэн агуулж байдаг)

Жил бүр урт, богино хугацааны эдийн засгийн төлөв байдлын мэдээллийг холбогдох (сангийн яам, эдийн засгийн хөгжлийн яам) яам дээрх хүчин зүйлүүдийн үзүүлэлтээр гаргадаг бөгөөд энэ төлөв байдалд үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулах нь үр дүнтэй.

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хангах нь цэргийн болон хууль сахиулах арга хэмжээнүүдтэй хосолсон чухал арга зам юм. Эдгээр арга хэрэгслүүд нь хилийн орчмын бүс нутаг дахь хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, эдийн засгийн өсөлт болон тогтвортой байдлыг дэмжихэд чухал үүрэгтэй.

Хил хамгаалах байгууллага нь Улсын хилийн аюулгүй байдлыг хангахын тулд эдийн засгийн онол, суурь үзүүлэлтийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байж хилийн аюулгүй байдлыг хангах хэрэгцээ, шаардлагын онол, практикт суурилан тодорхойлж эдийн засгийн боломжит хугацаа, нөөцүүдийн нэмэлтийн үеүдэд томоохон төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд анхаарах нь чухал гэж дүгнэж байна.

Эх сурвалж:

Монгол Улсын Их Хурал. (2016). Монгол Улсын Хилийн тухай хууль. *Төрийн мэдээлэл эмхэтгэл*.

Наранжамц, Н. (2008). *Улсын хил хамгаалалтын онол-практикийн үндсэн асуудлууд*.

Улаанбаатар: ДТС хэвлэх үйлдвэр.

Жанцан, Ц. (2012). Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр дэх дэд бүтэц, нийгэм эдийн засгийн хөгжлийг цогцоор шийдвэрлэх нь хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн. *“Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар.

Нямсүрэн, Ч & Чулуунбат, Ш. (2018). Улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй олон улсын эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ. *Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин судалгааны төсөлт ажлын тайлан*. Улаанбаатар.

Цэдэндагва, Г. (2013). *Эдийн засгийн ухаан*. Улаанбаатар : Улаанбаатар принт" ХХК.